



“Хөрөнгийн Зах Зээлийн Боловсрол” ТББ



ХЭРХЭН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ВЭ?

ГАРЫН АВЛАГА

2015 он

ӨМНӨХ ҮГ

Энэхүү гарын авлагыг Компанийн тухай хууль болон СЗХ-ноос баталсан холбогдох журамд заасны дагуу Хувьцаат компаниуд Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах талаар хувьцаат компанийн холбогдох ажилтан, хувьцаа эзэмшигчид болон иргэд олон нийтэд ерөнхий ойлголт өгөх зорилгоор бэлтгэлээ.

Ингээд бидний бэлтгэсэн энэхүү гарын авлага нь та бүхэнд ажил хөдөлмөрт бага ч болов тус болно гэж найдаж байна.

Зөвлөмж:

Энэхүү гарын авлагад Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах үйл ажиллагааны талаарх бүрэн мэдээлэл тусгагдаагүй байж болох ба танд “Компанийн тухай хууль” болон СЗХ-ны 2012.02.15-ны өдрийн 34 тоот тогтоолоор шинэчлэн баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ийг дэлгэрүүлэн үзэхийг зөвлөж байна.

**“Хөрөнгийн зах зээлийн
боловсрол” ТББ**

Бидэнтэй холбогдох: edu_hzz@yahoo.com


АГУУЛГА

- Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах
- Хурал зохион байгуулах
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын тайлан мэдээ

Хураангүй үгийн товчоо

КТХ	Монгол Улсын Компанийн тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ХЭ	Хувьцаа эзэмшигч
ТК	Хурлын тооллогын комисс
ЗБК	Хурал зохион байгуулах комисс

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЦАГ ХУГАЦААНЫ ҮЕЧЛЭЛ



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР ГАРГАХ

Хувьцаа эзэмшигчдийн хурал /ХЭХ/ бол компанийн эрх барих дээд байгууллага бөгөөд ХЭХ нь хоёр хэлбэртэй байдаг.



Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь КТХ-ийн 59.4-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах шийдвэр гаргана. Ээлжит хурлыг тухайн жилийн 5 сарын 1-ний дотор зарлан хуралдуулах ёстой байдаг бол ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.

Ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлөөс хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болдог. Иймд заасан хугацаанд зайлшгүй хуралдуулах шаардлагатай байдаг.

ХЭХурал хуралдуулах шийдвэрт дараах зүйлсийг зайлшгүй тусгана.

- ХЭХурал хуралдуулах газар, өдөр, цаг
- ХЭХурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт
- Бүртгэлийн өдөр*
- Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах материалууд
- ХЭХурлын санал авах хуудас
- Хурлын саналын хуудас авах сүүлийн өдөр
- ХЭХурлыг удирдах дарга, Зохион байгуулах болон Тооллогын комиссийн бүрэлдэхүүн

Ээлжит бус хурал

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг нэг жилд хэдэн ч удаа зарлан хуралдуулж болох бөгөөд дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулдаг.

- Компанийн ТҮЗ-ийн гишүүдийн 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй болсон, эсвэл ажиллахгүй болсон
- ТҮЗ-ийн хоёр буюу түүнээс дээш Хараат бус гишүүн санал гаргасан
- Компанийн саналын эрхтэй нийт хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч шаардсан
- Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30%-иас хэтэрсэн
- Компанийн өр нь 2 жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон
- Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан
Аудитын хороо шаардсан

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ

Хурлын мэдэгдэлийг ХЭХурал хуралдуулах шийдвэр гаргаснаас хойш 3 хоногийн дотор СЗХ болон МХБиржид хүргүүлэх ба мэдэгдэлд дараах зүйлсийг багтаана.

- ХЭХурал зарлах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол
- Хурлын мэдэгдэл
- Хурлын зарын загвар
- Хурлын дэг
- Хурлын материалтай танилцах баримт бичгийн жагсаалт
- Саналын хуудас


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТАЛААР ОЛОН НИЙТЭД ЗАРЛАХ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг МХБиржийн сайтад байршуулснаар нийтэд зарласанд тооцдог бөгөөд мөн энэ өдрөөр дараах мэдээллийн хэрэгслээр хамтатган олон нийтэд зайлшгүй зарлана.

*Өдөр тутмын 2
сонин*



*Орон даяар нэвтрүүлгээ
цацдаг 2 телевиз*



*Орон даяар нэвтрүүлгээ
цацдаг 2 радио*



- Компанийн өөрийн вэб хуудас
- Бусад олон нийтийн вэб хуудас болон бусад хэлбэрээр

Мөн ХЭХурлын зарыг анх зарласан өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин дээрх мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлах ёстой байдаг.

ХЭХурлын зард дараах зүйлсийг заавал тусгагсан байна. Үүнд:

- Компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, хуралдах газар
- Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөх
- Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг
- Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь
- Компанийн дүрэмд заасан болон хурал зарлагч этгээдээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл

Анхаарах зүйл:

Хурлын зарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласныг баталгаажуулах зар бүхий сонин, төлбөр төлсөн баримтаа хадгалах шаардлагатай байдаг бөгөөд уг нотлох баримтыг СЗХ болон МХБиржид хурлын тайланд хавсарган хүргүүлдэг юм.

ХЭХУРЛЫН МАТЕРИАЛЫГ ТАРААХ

Хувьцаат компани нь Хувьцаа эзэмшигчиддээ хурлаар хэлэлцэх асуудлууд, тэдгээрийн шийдвэрийн төсөл, компанийн үйл ажиллагаа, тайлан болон бусад шаардлагатай мэдээллийг багтаасан **ХУРЛЫН МАТЕРИАЛ** бэлтгэдэг.

Харин хурлын материалыг ХЭХурлын зарыг анх зарласан өдрөөс хойш 5 хоногийн дотор Брокерийн компаниудад тарааж, түүгээр дамжуулан Хувьцаа эзэмшигчиддээ танилцах боломжоор хангана. Хурлын материалыг өөрийн хувьцаа эзэмшигчдийн үйлчлүүлдэг Брокерийн компаниудын жагсаалтын дагуу тараахаас гадна бусад компанид хүргүүлнэ.

ХЭХ-ын ээлжит хурлын материал нь дараах зүйлсийг тусгасан байдаг.

- Компанийн жилийн бизнес үйл ажиллагааны тайлан
- Санхүүгийн аудитлагдсан тайлан, дүгнэлтүүд
- ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох бол нэр дэвшигчдийн танилцуулга
- Төлөөлөн Удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал болон зардлын төсөв
- Цаашид хэрэгжүүлэх бизнес үйл ажиллагааны төлөвлөгөө
- ХЭХурлын санал авах хуудас
- Бусад хэлэлцэх асуудал, түүнтэй холбоотой материалууд

БҮРТГЭЛИЙН ӨДРИЙГ ТОГТООХ



Бүртгэлийн өдөр* гэдэг нь Хувьцаа эзэмшигчдийн хуралд суух эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг тогтоох сүүлийн өдөр юм. Өөрөөр хэлбэл энэ өдөр тухайн компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд сууна гэсэн үг.

Компани нь Бүртгэлийн өдрөөр хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг хурал хуралдахаас өмнө “ҮЦТТТХТ” ХХК-иас гаргуулан авдаг бөгөөд уг жагсаалтын дагуу хувьцаа эзэмшигчиддээ хуралд оролцуулна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагаа дараах үе шаттайгаар явагддаг бөгөөд ингэхдээ хурлын дэгийг баримтлана.



ХЭХурлын хуралдах цаг, өдөр, газар болон хурлаар хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулахыг хориглодог бөгөөд ингэсэн тохиолдолд тухайн хурлыг хүчингүй болгох үндэслэл болно.

Хурлын үеэр анхаарах зүйлс:

- ХЭХурлыг дэгийн дагуу хуралдуулах
- Хэлэлцэж буй асуудлуудыг ойлгомжтой, дэлгэрэнгүй тайлбарлах
- Хувьцаа эзэмшигчдэд хэлэлцэж буй асуудлын талаар санал бодлоо илэрхийлэх, асуулт асуух боломжийг олгох
- Санал хураах, саналын хуудас хэрхэн бөглөх талаар заавар зөвлөгөө өгөх

Тооллогын комисс /ТК/

ТК нь ХЭХурлын үеэр дараах үйл ажиллагаа, үүргийг хэрэгжүүлнэ.

Тухайлбал:

- ХЭХурлын ирцийг гаргаж, Хурлын даргад мэдэгдэнэ
- ХЭХурлын хэлэлцэх асуудал тус бүрээр ХЭ-ийн саналын эрхийн тоо, төрлийг тогтоох
- ХЭ-ийн хуралд оролцон санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуудалд тайлбар өгөх
- Санал өгөх журмыг тайлбарлах, заавар зөвлөгөө өгөх
- ХЭ-ийн санал өгөх эрхийг хангах
- Саналын хуудас хүлээн авч тоолох, санал хураалтын дүнг нэгтгэн гаргаж, ТК-ийн тогтоол гаргаж, ТК-ийн дарга хуралд танилцуулах гэх мэт.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮЮУ ТАЙЛАН

Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулагдсаны дараа Ээлжит хурлын материалыг “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 10.1.5-д болон “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасны дагуу 6 сарын 1-ний дотор, Ээлжит бус хурлын материалыг хурал хуралдсанаас хойш 20 хоногийн дотор СЗХ болон МХБиржид албан бичгээр хүргүүлнэ.

Албан бичигт дараах материалыг хавсаргана. Үүнд:

- ХЭХурлын тогтоол буюу шийдвэр
- ХЭХурлын тэмдэглэл
- Тооллогын комиссийн тогтоол
- ХЭ-ийн саналын хуудсууд
- Хурлын зарыг олон нийтэд зарласныг нотлох баримт бичиг
- Хурлын материал
- Бусад холбоотой материал



“ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН
БОЛОВСРОЛ” ТББ

Хөрөнгийн зах зээлийн талаарх
илүү их мэдээллийг:

[www.facebook.com/
маркетинфо](http://www.facebook.com/маркетинфо)